



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/95

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах
тухай


Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 301 дүгээр тушаал, Үндэсний статистикийн хорооны Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар бүлгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Хүнсний баталгаат байдлын алдагдлыг тооцох туршилтын судалгаа”-ны мэдээлэл цуглуулах орон нутгийн судлаач нарт зориулсан сургалтыг зохион байгуулж, мэдээлэл цуглуулалтын ажлыг эхлүүлэх ажлаар Эдийн засгийн статистикийн газрын Эдийн засгийн статистикийн албаны статистикч Э.Мягмарханд, Р.Энх-Амгалан нарыг Ховд аймагт 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 23-ны өдрүүдэд, Хүн ам нийгмийн статистикийн газрын Өрхийн орлого, зарлагын судалгааны албаны статистикч Н.Хэнбиш, Эдийн засгийн статистикийн газрын Эдийн засгийн статистикийн албаны статистикч Э.Мягмарханд нарыг Сүхбаатар аймагт 2019 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 28-ны өдрүүдэд томилон ажиллуулсугай.

2.Сүхбаатар, Ховд аймагт ажиллах томилолтын зардлыг холбогдох төсвөөс гаргахыг Тамгын газрын Санхүүгийн хэлтэс /Д.Батсүх/-т зөвшөөрсүгэй.

3.Албан томилолтын ажлын тайланг 3 хоногт багтаан Тамгын газарт илтгэх хуудсаар танилцуулахыг Эдийн засгийн статистикийн газрын Эдийн засгийн статистикийн албаны статистикч Э.Мягмарханд, Р.Энх-Амгалан, Хүн ам нийгмийн статистикийн газрын Өрхийн орлого, зарлагын судалгааны албаны статистикч Н.Хэнбиш нарт даалгасугай.

ДАРГА



Ч.ЦЭВЭГДОРЖ

000899